

# **ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ГУРВАН ТАЛТ 2026-2028 ОНЫ УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭР**

## **Удиртгал**

Монгол Улсын эдийн засаг 2025 онд 6.8 хувиар өссөн байна. Үндэсний статистикийн хорооны 2025 оны 4 дүгээр улирлын мэдээгээр ажиллах хүчний оролцооны түвшин 62.3 хувьд хүрч, өмнөх оноос өссөн үзүүлэлттэй, ядуурлын түвшин 27-28 орчим хувьд хадгалагдаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд төдийлөн буураагүй байна.

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуй, худалдаа зэрэг ажиллах хүчний шингээлт ихтэй ч хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлс бага салбаруудад ажиллагчид их хэвээр байна. Хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээ зэрэг салбарууд нь нийгмийн хамгааллын хамрагдалт сул, албан бус хөдөлмөр эрхлэлт давамгайлсан хэвээр байгаа бөгөөд нийт ажиллах хүчний 40 гаруй хувийг эзэлж байна.

Нөгөө талаас эдийн засгийн салбаруудад ур чадвартай ажиллах хүчний хомсдол үргэлжилсээр байгаа нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, өсөлтийг хязгаарлах хүчин зүйл болж байна. Иймд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өндөр ур чадвартай ажиллах хүч бэлтгэх бодлогыг төр, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагууд хамтран боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Монгол Улсын хувьд цалингийн ДНБ-д эзлэх хувь адил түвшний улсуудаас 8.7-13.3 нэгжээр доогуур байна. Мөн төрийн албан хаагчдын цалин хөлсний нэгдсэн тогтолцоог бий болгох, цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой салбарын хуулиудаар ялгаатай, харилцан адилгүй тусгагдсан заалтуудыг нэг мөр цэгцлэх, давхардлыг арилгах, шалгуур үзүүлэлт, хамрах хүрээг нэг жишигт нийцүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээрийг дүгнэж, цаашид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгааллын баталгааг хангах чиглэлээр хамтран ажиллахаар Хөдөлмөрийн тухай хуулийн 34.1.1-д заасны дагуу энэхүү хэлэлцээрийг байгуулав.

## **Нэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр баримтлах бодлогын чиглэл**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль эрх зүйн орчныг шинэчлэх, бүс орон нутаг, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг төр-хувийн хэвшлийн түншлэлээр хүртээмжтэй болгох дунд хугацааны бодлогын зорилтуудыг хэрэгжүүлнэ:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барина. Хуулийг

шинэчлэхдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зорилтот бүлгийг нарийвчлан тодорхойлж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд кейс менежментийн аргачлалыг нэвтрүүлж, бүртгэл мэдээллийн тогтолцоог их өгөгдөлд суурилсан хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо болгон зориулалт, хэрэглээг өргөжүүлнэ. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, ажил олгогч, ажил хайгчийн үүрэг, оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх болон хуулийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээг боловсронгуй болгоно.

2.Халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох зарчмыг нэвтрүүлж, халамж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын уялдааг хангах “Халамжаас хөдөлмөрт” бодлогыг бодитойгоор хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барина.

3.Зорилтот өрх, иргэний хэрэгцээ, санаачилга, боломжид тулгуурлан өрхийн амьжиргааг дээшлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, санхүү, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг цогц үйлчилгээнд хамруулах, хөдөлмөрийн чадвартай, ажил олоход хүндрэлтэй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар зорилтот өрхийн бие даан амьдрах чадавхыг сайжруулах “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 5000 өрхийг хамруулна.

4.Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлаас гаргах үндэсний санаачлага”-ыг талууд дэмжиж ажиллана.

5.Залуучуудын хөдөлмөрт хандах хандлага, бүтээлч байдлыг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн оролцоог дэмжих замаар эх орондоо бүтээмжтэй, тогтвортой хөдөлмөр эрхлэхэд нь хувь нэмэр оруулах зорилготой “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн хүн амын бүлгүүдийн /эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчин/ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.Шинэ техник, технологи, дижитал шилжилтийн нөхцөл байдалтай холбоотойгоор дижитал хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийж, бодлогын дүгнэлт гаргаж, хэрэгжүүлнэ.

7.Мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн хэрэгцээ, шаардлага, ажлын байранд тавигдах ур чадвартай уялдуулна.

8.Хөдөлмөрийн зах зээлийн дунд, урт хугацааны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг олон улсын аргачлалын дагуу үндэсний хэмжээнд хийж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн салбар дундын систем хөгжүүлж, ажил олгогч, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хамтран ажиллана.

9.“Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт YAMAT-08”-ыг жил бүр талууд хамтран сайжруулалт хийнэ.

10.Ажлын байрны хэмжилт судалгаа, үнэлгээгээр хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй нь тогтоогдсон ажлын байрны нөхцөлийг сайжруулах улмаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”, “Газрын доор, хөдөлмөрийн хортой,

халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам"-ын хэрэгжилтийг дүгнэж, талуудын оролцоог ханган, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авна.

11. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээлээр санхүүжүүлж байгаа бүтээн байгуулалтын төсөл, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төндэрийн баримт бичигт үндэсний болон аж ахуйн нэгж, байгууллага, орон нутгийн иргэдийн оролцоог хангах нөхцөлийг тусгана.

### **Хоёр. Цалин хөлс, орлогын талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлогын чиглэл**

Засгийн газрын зүгээс төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны байдлаар улсын дундаж цалин хөлс 2,726.9 мянган төгрөг, хувийн хэвшлийн ажиллагчдын дундаж цалин хөлс 2,770.3 мянган төгрөг, төрийн албан хаагчдын дундаж цалин хөлс 2,635.3 мянган төгрөг байна. Мөн инфляцын өсөлт нь цалин хөлс, иргэдийн бодит орлогод сөргөөр нөлөөлж, худалдан авах чадварыг бууруулж байна. Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, бага орлоготой иргэдийн орлогыг хамгаалах хүрээнд төрийн албан хаагчдын цалин хөлсний нэгдсэн тогтолцоог бий болгох, цалин хөлсний бүтцийг шинэчлэх, гүйцэтгэл, үр дүнтэй уялдсан цалин хөлсний системийг нэвтрүүлэх зэрэгт чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1. Татвар, эрүүл мэндийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, ажил олгогчид ээлтэй, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх, татварын дарамт, ачааллыг бууруулахад чиглүүлж, бизнесийн өсөлт, ажилтны цалин хөлсийг нэмэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, худалдан авах чадварыг сайжруулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Цалин хөлсний талаар Үндэсний хэмжээнд баримтлах бодлогын баримт бичигт үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулж Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороогоор батлан, хэрэгжилтийг хангаж ажиллана.

3. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр гарах үр дагавар, нөлөөллийн талаар тооцоолол хийж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2027 онд нэмэгдүүлэн тогтооно.

4. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, цалин хөлсний бүтцийг оновчтой болгох, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

5. Бүтээмж ба цалин хөлсний уялдааг хангах, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор "Бүтээмжийн мастер төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

6. Цалин хөлсний бүтцийн судалгааг боловсронгуй болгож, тарифт цалин, нэмэгдэл, шагнал урамшууллын системийг тогтоох асуудлыг өөрийн салбар, байгууллагын онцлогт тохируулан хамтын гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэх чадавхыг салбарын түвшний нийгмийн түншлэгч талуудад бий болгоно.

7. Ахмад настны тухай хуулийн 4.1.2, 14.7-д заасан “Ахмадын сан” байгуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасан зардлыг улсын төсвийн зардлын ангилалд тусгах, хэрэгжүүлэхэд талууд хамтран ажиллана

8. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй уялдуулан цалин хөлсний эзлэх хувийг жил бүр нэмэгдүүлэх бодлого баримтална.

9. Аж ахуйн нэгж, байгууллага цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр шийдвэрлэнэ.

10. Улсын төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ салбарын яамдын түвшинд төсвийн саналаа Засгийн газарт хүргүүлэхээс өмнө тухайн шатны үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай, Засгийн газрын түвшинд төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө МҮЭХ, МАОЭНХ-той үндэсний хэмжээнд нийгмийн түншлэлийн хүрээнд зөвшилцөнө.

11. Хөдөлмөр эрхлэгчдийн орлогыг хамгаалах, хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тогтоох асуудлуудыг холбогдох Үндэсний хороо, зөвлөл, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагаар хэлэлцүүлж, зөвшилцөх бодлого баримталж ажиллана.

12. Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагыг хувьчлах хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хувьцааны тодорхой хэсгийг тухайн байгууллагын ажилтнуудад эзэмшүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэл баримтална.

### **Гурав. Хүний хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар баримтлах бодлогын чиглэл**

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24, 25 дахь илтгэлд дурдсан хөдөлмөрийн хүрээний үндсэн эрхийн хэрэгжилтэд хийсэн дүгнэлт, хүний хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангах, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хууль тогтоомжийн зохицуулалтаар хязгаарлагдахгүй, харин хяналт-шинжилгээ, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, ажил олгогч, ажилтны харилцаанд тэнцвэртэй оролцоог хангах бодлогын арга хэмжээг төлөвлөж ажиллах зөвлөмжийн хүрээнд нийгмийн түншүүд дараах чиглэлээр хамтран ажиллана:

1. Хууль тогтоомжийн хуулийн дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, хууль тогтоомжийг сайжруулах санал боловсруулна.

2. Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, сургалт, сурталчилгааны ажлыг нийгмийн түншлэгч талууд хамтран зохион байгуулна. Дагалдах журмуудын хэрэгжилтэд хяналт тавих механизмыг сайжруулах, үйлдвэрчний эвлэл, ажилтны төлөөлөгчийн хяналтын оролцоог баталгаажуулна.

3. Нийгмийн даатгалын шинэчлэлийг үргэлжлүүлж, тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, нийгмийн даатгалын сангуудын тогтвортой байдал, засаглалыг сайжруулах замаар ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр авагч төвтэй, хүртээмжтэй, чанартай нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлнэ.

4. Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжиж, тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.

5.Төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын зайнаас, цахимаар ажиллах, ажлын цагийн уян хатан нөхцөлийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулна.

6.Ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагууд хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамруулахад ажил олгогчдын байгууллага бодлогын дэмжлэг үзүүлнэ.

7.Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд үе шаттайгаар шилжих зорилтын хүрээнд ажил олгогчид ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулж, бүтээмжээ дээшлүүлэх, санхүүгийн зах зээлийг дэмжих, иргэд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулна.

8.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн хяналтын тухай” 81, 129 дүгээр конвенцид нэгдэн орох асуудлыг УИХ-аар хэлэлцүүлнэ.

9.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Ажлын байрны дарамт, хүчирхийллийг устгах тухай” 190, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай” 187 дугаар конвенцийн суурь судалгааг хийнэ.

10.Төрийн албан хаагч, ажилтныг үйлчлүүлэгч болон бусад этгээдийн зүгээс ирэх дарамт, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ажлын орчин нөхцөлийг сайжруулах, ажилтныг хамгаалах бодлого, тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авна.

11.Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэл мэдээлэл, эдийн засаг, санхүүгийн болон нийгмийн хамгааллын баталгаагаар дэмжин албан секторт шилжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

12.Эрүүл мэндийн даатгалаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, хувийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог дэмжинэ.

13.Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, чиг үүрэгт өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах, хэлэлцэх, шийдвэрлэх явцад үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангаж, урьдчилан зөвшилцөнө.

14.Ипотекийн зээл болон түрээслээд өмчлөх орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээний хэрэгжилтэд төр, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагуудын оролцоог хангаж, нийгмийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлэх чиглэл баримтална.

15.Төрийн албан хаагчийн 9 хувийн цомхотголыг зогсоох, чиг үүргийн давхардлыг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нийгмийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллана.

### **Дөрөв. Нийгмийн түншлэл, тэгш байдал**

Нийгмийн түншлэлийг бүх түвшинд хөгжүүлэх, нийгмийн тэгш байдлыг хангах, хамтын хэлэлцээ хийх чадавхыг бэхжүүлэх, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх тогтолцоог сайжруулах, бүх түвшний хамтын хэлэлцээ, хамтын гэрээ, хэлэлцээрийн ач холбогдлын талаар олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхэд нийгмийн түншүүд дараах чиглэлээр хамтран ажиллана:

1.Нийгмийн түншлэлийг бүх түвшинд хөгжүүлэх, нийгмийн тэгш байдлыг хангах, хамтын хэлэлцээ хийх чадавхыг сайжруулах, салбар, салбар дундын хэлэлцээр, хамтын гэрээ, хэлэлцээрээр цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, талууд үүрэг хариуцлагаа хүлээж, хэрэгжүүлдэг жишиг, соёлыг бий болгоход хамтарч ажиллана.

2.“Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэн, Монгол Улсын Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг дарга, сайд нартай байгуулдаг хариуцлагын гэрээнд Сайдын зөвлөл болон Засаг даргын зөвлөлд нийгмийн түншлэгч талуудын төлөөллийг оруулах талаар тусгана.

3.Салбар, салбар дундын түвшинд хамтын хэлэлцээ хийх, байгуулах, хэрэгжилтийг хангахад арга зүйн зөвлөмж, чиглэл өгч хамтран ажиллана.

4.Хөдөлмөрийн эрхийн болон сонирхлын маргаанаас урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн ажлыг эрчимжүүлж, маргаан шийдвэрлэх байгууллага, хөдөлмөрийн зуучлагч, арбитрчдыг чадавхжуулахад нийгмийн түншүүд хамтран ажиллана.

5.Салбарын гэрээ, хамтын хэлэлцээрийн бүртгэл, хөдөлмөрийн маргаан зохицуулалтын асуудлаар цахим бүртгэл мэдээллийн санг бүрдүүлнэ.

6.Ажил олгогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах, захиргааны хэм хэмжээний актуудыг зохистой түвшинд байлгах, бизнесийн үйл ажиллагаанд хэт давхардсан хяналт, шалгалтыг бууруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлнэ.

7.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хувийн хэвшилтэй адил нөхцөлд, ил тод, шударга өрсөлдөөний зарчмаар үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, давуу байдал үүсгэж болзошгүй санхүүгийн болон бусад дэмжлэгийг үе шаттай бууруулна.

8.Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ажлын байрыг хадгалах зорилгоор ажил олгогч, ажилтанд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

9.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны дэргэд тал бүрийн оролцоотой Ажлын албыг байгуулж, ажлын албаны гишүүд тус тусын ажлын байран дээр ажиллана.

10.Төрийн зарим чиг үүргийг үйл ажиллагааны чанар, орлого, зардал, үр ашгийн тооцоо судалгаан дээр үндэслэн мэргэжлийн холбоод, хувийн хэвшилд шилжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

11.Засгийн газар хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн хууль тогтоомжийг шинээр батлуулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө үйлдвэрчний эвлэл болон нийгмийн түншлэгч талуудтай урьдчилан зөвшилцөнө.

## **Тав. Хэлэлцээрийг мөрдөх, хэрэгжүүлэх асуудал**

1. Энэхүү хэлэлцээр нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

2. Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ хэлэлцээр байгуулаагүй, эсвэл нэмэлт, өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөнө.

3. Хэлэлцээрийн биелэлтэд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо, хэлэлцээрт оролцогч талууд хамтран хяналт тавина.

4. Улсын хэлэлцээрийн биелэлтийг жил бүр дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороогоор хэлэлцүүлэн олон нийтэд мэдээлнэ.

5. Засгийн газар, ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлүүдийн холбоодын удирдлага, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, шинэчлэн зохион байгуулагдах нь энэхүү хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн залгамжлагчид энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

6. Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулахад энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримталсан журмыг дагаж мөрдөнө.

7. Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Хэлэлцээрийн төлөвлөгөөг талуудын болон холбогдох яам, газрын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

8. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд үүссэн маргааныг хамтран хэлэлцэж, тохиролцох бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД, ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
АХЛАГЧ

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Т.АУБАКИР

Э.БАТАМГАЛАН

Ц.ИДЭРБАТ

Э.БАТШУГАР

И.БАТХҮҮ

Б.АНАР

Б.ДАШПҮРЭВ

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Т.НЯМ-ОЧИР

**МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:**

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АХЛАГЧ



Э.ТАМИР

МОНГОЛЫН ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗРЫН  
ТОСНЫ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ  
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

М.БОЛДСАЙХАН

МОНГОЛЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ  
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

О.ГАНТУЯА

МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ  
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ  
ДАРГА

Ч.НАРАНТУЯА

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ  
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

Х.БАТЖАРГАЛ

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН  
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ  
ДАРГА

Ё.СОЁЛМАА

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ  
УУРХАЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОЛБООНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, УУЛ УУРХАЙ ХАРИУЦСАН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

А.ДАГВАДОРЖ

МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОЛБООНЫ ДАРГА

З.ЦОГТГЭРЭЛ

**АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН НЭГДСЭН  
ХОЛБООНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ,  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АХЛАГЧ



Ч.НАНЖИДСАМБУУ

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН  
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ӨЛЗИЙБАТ

МОНГОЛЫН НООС НООЛУУРЫН ХОЛБООНЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.АЛТАНЦЭЦЭГ

МОНГОЛЫН ХҮНСЧДИЙН НЭГДСЭН  
ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.НАРМАНДАХ

МОНГОЛЫН ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГДСЭН  
ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ДОРЖГҮНСМАА

МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБООНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ  
АССОЦИАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

З.БАТБАЯР

МОНГОЛЫН ХУВИЙН СУРГУУЛИУДЫН  
ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

П.ОЮУНБИЛЭГ

Г.ӨНӨРСАЙХАН

2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр